



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2005 оны 8 сарын 3 өдөр

Дугаар 313

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн бирж байгуулах тухай

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хэрэгжүүлэгч агентлаг, Захирагчийн ажлын алба, харьяа газруудын бүтэц, орон тоог тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолын 4, 8 дах заалт, Нийслэлийн Засаг даргын 2005 оны 22 дугаар захирамжийн хавсралтын 8 дах хэсэг, Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр нийгмийн хамгааллын газрын дэргэд Нийслэлийн хөдөлмөрийн биржийг байгуулж тус биржийн дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. "Нийслэлийн хөдөлмөрийн бирж" шинээр байгуулах, гадаадад хөдөлмөр эрхлэх, жижиг дунд үйлдвэрт дадлагажих хүсэлт тавьсан иргэдийг сонгон шалгаруулж явуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засаг даргын нөөц хөрөнгөөс 8 000 000 /найман сая/ төгрөгийг гаргаж Нийслэлийн Хөдөлмөрийн биржид олгохыг Тамгын газар /Ц.Болдсайхан/-т зөвшөөрсүгэй.

Гурав. Нийслэлийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг 2006 оноос эхлэн нийслэлийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт даалгасугай.

Дөрөв. Нийслэлийн хөдөлмөрийн биржийн мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах ажлыг төслийн дагуу "Цахим-Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд хамруулан эхний ээлжинд хэрэгжүүлэхийг Ажлын хэсэг /Ц.Болдсайхан/, Нийслэлийн Мэдээллийн технологийн газар /Ж.Сансар/-т даалгасугай.

Тав. Нийслэлийн "Хөдөлмөрийн бирж"-ийн бүтэц, орон тоог баталж, үйл ажиллагааг нь үр дүнтэй удирдан зохион байгуулахыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын газар /Ж.Жанцан/-т даалгасугай.

Зургаа. Энэ захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч Б.Баатарзоригт даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

My dok Zakiramj-04

0201059

Нийслэлийн засаг даргын 2005 оны 8 дугаар сарын 3 ны өдрийн 118 захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ХӨДӨЛМӨРИЙН БИРЖИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын газар /цаашид "ХНХГ" гэх/-ын дэргэдэх "Хөдөлмөрийн бирж" /цаашид "бирж" гэх/ нь нийслэлийн хэмжээгээр хөдөлмөрийн зах зээлийн харилцааг зохицуулж ажил хайгч иргэн, ажил олгогч тэдгээрт үйлчилэгч байгууллага, хувь хүмүүст нийслэлийн төр, захиргааны байгууллагын нэрийн өмнөөс үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах үйл ажиллагааг эрхлэнэ.
- 1.2 Бирж нь үйл ажиллагаандаа Монгол улсын үндсэн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Улсын Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр, Засаг даргын мөрийн хөтөлбөр, захирамж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.
- 1.3 Бирж нь Нийслэлийн Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Газрын дэргэд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын мэргэжил арга зүйн болон төсөв санхүүгийн дэмжлэг туслалцаанд тулгуурлан ажиллана.
- 1.4 Нийслэлийн засаг дарга нь биржийн захирлыг томилж, чөлөөлөх бөгөөд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн биржийн орон тоо, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын газрын дарга Нийслэлийн Засаг Даргатай зөвшилцөн шийдвэрлэнэ.
- 1.5 Биржийн захирал эрх хэмжээний асуудлаар тушаал гаргаж, биржийн дотоод журмыг тогтоож мөрдүүлнэ.
- 1.6 Бирж нь өөрийн билэгдэл, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.
- 1.7 Биржийн үйл ажиллагааг нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, өөрийн орлогоос дэмжлэг үзүүлнэ. Өөрийн орлогыг бүртгэлийн хураамж, үйлчилгээ, зуучлалын төлбөр, хууль тогтоомжинд нийцүүлэн гэрээгээр гүйцэтгэсэн ажлын орлогоор бүрдүүлнэ.

Хоёр. Биржийн үүрэг

- 2.1 Бирж нь Монгол улсын Засгийн газрын болон Нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудад тусгагдсан

хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг хангах, ажилгүйдлийг бууруулахад идэвхитэй тус дөхөм үзүүлэх;

- 2.2 Нийслэлийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сүлжээг хэрэгжүүлж ажилгүйчүүд, ажил олгогчид, сургалтын байгууллага, хөдөлмөрийн бусад биржүүд, ТББ, иргэд хэвлэл мэдээллийн байгууллага, гадаад дотоодын түншүүдтэй шаардлагатай мэдээлэл солилцох, зөвлөлгөө өгөх, хамтарч ажиллах;
- 2.3 Ажил олгогчдоос шаардлагатай ажлын байрны захиалгыг авч бүртгэлтэй ажилгүйчүүдийг зуучлах;
- 2.4 Нийслэлийн иргэдийн гадаадын өндөр орнуудад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, жижиг дунд үйлдвэрт суралцаж, дадлагажих хүсэлт тавьсан иргэдийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх (Энэхүү үйл ажиллагааг хуульд нийцүүлэн тусгайлан батлагдсан журмаар зохицуулна)
- 2.5 Бирж нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлд тусгагдсан иргэдийг мэргэжил олгох болон давтан сургалтанд хамруулах үйлчилгээг зохицуулж хэрэгжүүлэх;
- 2.6 Хөдөлмөрийн зах зээлд эрэлт, хэрэгцээ ихтэй байгаа мэргэжлийн түр сургалтыг эрхийн бичгээр зохион байгуулж, төгсөгчдийг ажлын байраар ханган нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх;
- 2.7 Биржийн эрхлэх асуудлаар гарсан хууль, Засгийн газрын болон Яам, агентлагын тушаал, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Хөдөлмөр нийгмийн хамгааллын газрын шийдвэр үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг тооцож мэдээлэх;
- 2.8 Хөдөлмөр эрхлэлттэй холбогдуулж иргэд, ажил хайгч болон ажил олгогчдын тавьсан санал, өргөдөл, гомдлыг барагдуулах.

Гурав. Биржийн эрх

- 3.1. Биржийн төсвийг, хуулийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах;
- 3.2. Биржтэй холбогдсон асуудлаар шаардлагатай мэдээ, баримт материал, тооцоо судалгааг нийслэл, дүүргийн төрийн болон төрийн бус байгууллага болон өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаар гаргуулан авах;
- 3.3. Шаардлагатай тохиолдолд биржийн эрхлэх асуудлаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний үндэслэл баталгаа, нөхцлийг хянан үзэх;
- 3.4. Өөрийн үйл ажиллагааны чиглэлээр гадаад, дотоодын байгууллага, олон улсын байгууллагатай хууль журмын дагуу хамтран ажиллах;
- 3.5. Биржийн үйл ажиллагааны ойрын ба дунд хугацааны болон хэтийн зорилт, төсөөлөл, төсвийн төслийг боловсруулж харъяалах дээд байгууллагад оруулж шийдвэрлүүлэх
- 3.6 Нийслэлийн хөдөлмөрийн зах зээлийн байдлыг нийтэд мэдээлж байх зорилгоор "Биржийн мэдээ" сонин хэвлүүлж түгээх.